



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2008 оны 04 сарын 18 өдөр

Дугаар 80

Улаанбаатар хот

“Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн холбогдох этгээдтэй холбоотой этгээдийг тодорхойлох заавар” батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, Даатгалын тухай хуулийн 65.3, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 34.3 дахь хэсгийг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1.“Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн холбогдох этгээдтэй холбоотой этгээдийг тодорхойлох заавар”-ыг хавсралтаар баталсугай.

2.Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Даатгалын газар /С.Ганболд/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /Б.Мөнхжаргал/-г тус тус даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

ДААТГАГЧИЙН БОЛОН ДААТГАЛЫН МЭРГЭЖЛИЙН ОРОЛЦОГЧИЙН ХОЛБОГДОХ ЭТГЭЭДТЭЙ ХОЛБООТОЙ ЭТГЭЭДИЙГ ТОДОРХОЙЛОХ ЗААВАР

НЭГ. Ерөнхий зүйл

1.1.Энэ зааврын зорилго нь даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтад хамаарах холбогдох этгээдийн үйл ажиллагаанд шалгалт хийх харилцааг зохицуулах, Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-ны мэдээлэл цуглуулах эрхийг нарийвчлан тогтоох, Даатгалын тухай хуулийн 65.3 болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 34.3-г тус тус заасны дагуу даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн холбогдох этгээдтэй холбоотой этгээд (цаашид “холбоотой этгээд” гэх)-ийг тодорхойлоход оршино.

1.2.Хорооноос даатгагчийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтад хамаарах буюу Даатгаалын тухай хуулийн 13 дугаар бүлэгт заасан “холбогдох этгээд” гэдэгт даатгагч болон даатгагч байсан этгээд, эсхүл түүний хараат болон охин компанийг хэлнэ.

1.3.Хорооноос даатгалын мэргэжлийн оролцогчийн үйл ажиллагаанд хийх хяналт шалгалтад хамаарах буюу Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 8 дугаар бүлэгт заасан “холбогдох этгээд” гэдэгт даатгалын мэргэжлийн оролцогч болон даатгалын мэргэжлийн оролцогч байсан этгээд, эсхүл түүний хараат болон охин компанийг хэлнэ.

ХОЁР. Даатгагчийн болон даатгалын мэргэжлийн оролцогчийн холбогдох этгээдтэй холбоотой этгээдийг тодорхойлох

2.1.Холбоотой этгээд гэж Даатгалын тухай хуулийн 61 болон Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хуулийн 30.1-д тус тус заасан даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогчийн холбогдох этгээдтэй холбоотой дараах этгээдийг хэлнэ. Үүнд:

- 2.1.1.Хувь нийлүүлэгч болон хувьцаа эзэмшигч;
- 2.1.2.Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга;
- 2.1.3.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн;
- 2.1.4.Гүйцэтгэх удирдлага;
- 2.1.5.Хорооноос холбоотой этгээд гэж үзсэн бусад этгээд.

2.2.Энэ зааврын 2.1.1, 2.1.2-т заасан этгээдэд даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, эсхүл даатгагч байсан болон даатгалын мэргэжлийн оролцогч байсан этгээд, эсхүл тэдгээрийн хараат болон охин компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө, хувьцааны хяналтын багцыг эзэмшиж буй этгээд, эсхүл эдгээр компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө болон хувьцааны хяналтын багцыг эзэмшиж байсан этгээд хамаарна.

2.3.Энэ зааврын 2.1.3, 2.1.4-т заасан этгээдэд даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, эсхүл даатгагч байсан болон даатгалын мэргэжлийн оролцогч байсан этгээд, эсхүл тэдгээрийн хараат

болон охин компанийн ТУЗ-ийн дарга, гишүүнээр сонгогдон ажиллаж байгаа, эсхүл үүнээс өмнө эдгээр компанийн ТУЗ-ийн дарга, гишүүнээр сонгогдож байсан этгээд хамаарна.

2.4.Энэ зааврын 2.1.5-д заасан этгээдэд даатгагч болон даатгалын мэргэжлийн оролцогч, эсхүл даатгагч байсан болон даатгалын мэргэжлийн оролцогч байсан этгээд, эсхүл тэдгээрийн хараат болон охин компанийн гүйцэтгэх захирал, дэд захирал, ерөнхий менежер, ерөнхий нягтлан бодогч зэрэг удирдах албан тушаалд томилогдон ажиллаж байгаа, эсхүл үүнээс өмнө эдгээр компанийн гүйцэтгэх захирал, дэд захирал, ерөнхий менежер, ерөнхий нягтлан бодогч зэрэг удирдах албан тушаалд томилогдон ажиллаж байсан этгээд хамаарна.

ГУРАВ. Хяналт, хариуцлага

3.1. Хороо нь энэ зааврын хэрэгжилтэд хяналт тавих бөгөөд холбоотой этгээд нь Хорооноос тавьсан шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд Даатгалын тухай хууль, Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

--ooOoo--